

Төв Азийн цэвэр ус: Их гүрнүүдийн бодлого болон ирээдүйн чиг хандлагын талаарх таамаглал

С.Чулуундорж

Үндэсний батлан хамгаалахын их сургууль

ABSTRACT

This article analyzes the geopolitical significance of transboundary water resources in Central Asia, especially the Amu Darya, Syr Darya, Ili, Irtysh, Chu, and Talas rivers and the water and mountain ice caps, the policy orientations of the great powers (China, Russia, the United States, and the EU), the intersection of regional internal interests, and the risk map. The scarcity of fresh water is a factor affecting not only economic development, but also regional security and political stability. The term Central Asia includes the territories of Kazakhstan, Kyrgyzstan, Tajikistan, Turkmenistan, and Uzbekistan. Water-rich Kyrgyzstan and Tajikistan are mountainous and have upstream sources, while Kazakhstan, Uzbekistan, and Turkmenistan are downstream users. Unequal distribution of water creates constant tension in political and economic relations.

The collapse of the Aral Sea and the melting of the Tenger Mountains and Pamir glaciers are further exacerbating the problem of water scarcity and increasing geopolitical risks. The involvement of great powers has made water management not just a domestic issue but a strategic factor affecting regional stability.

Keywords: *Central Asia, water security, great powers, geopolitics, transboundary rivers*

ОРШИЛ

2016 оны 06 дугаар сарын 23-нд Ташкентад болсон ОХУ, БНХАУ, МУ-ын төрийн тэргүүний дээд хэмжээний уулзалтын үеэр ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин “Монголын Сэлэнгийн сав газарт барих усан байгууламжууд нь Иркутскийн усан хангамж, Байгаль нуурын экологид эрсдэл учруулж болзошгүй” гэж мэдэгдээд Монгол Улсад эрчим хүчний нийлүүлэлтийг нэмэх санал тавьсан. Үүний дагуу НҮБ-ын Дэлхийн Өв Хорооны 40 СОМ 7В.97 тогтоолоор Эгийн голын УЦС-ын байгаль орчны үнэлгээг Байгаль нуурын Дэлхийн өвийн үнэт чанарт (OUV) шууд холбогдуулан нарийвчлалт хийхийг Монгол Улсаас шаардаж, бүрэн тайланг ЮНЕСКО-д ирүүлэхийг даалгасан. Энэ нь олон улсын шугамаар Эгийн голын ЭЦС нь “түр азнах” нөхцөл байдал үүсжээ. Бид энэхүү эдэрэт нөхцөл байдлыг тодорхой болгохын тулд усны менежмент болон усны геополитикийн асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлах оролдлого хийж байна.

Хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхийг сөхөн үзвэл Нил, Инд, Тигр, Евпрат, Шар мөрний дагуу суурин соёл иргэншил, харин Хэрлэн, Онон, Туул, Сэлэнгийн ай саваар нүүдлийн соёл иргэншил цэцэглэн хөгжсөөр балар эртний

үеэс өнөө үетэй золгожээ. Хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжил дэвшил нь гол мөрний ай сав, уул усыг түшиглэдэг нь хүний амьдрах таатай нөхцөлөөс гадна, эдийн засаг, худалдаа арилжаа, үйлдвэрлэл явуулах үндэс болдогтой салшгүй холбоотой билээ.

Төв Ази нь усны нөөцийн хувьд дэлхийн хамгийн эмзэг цэгүүдийн нэг бөгөөд Урал, Алтай, Памир, Тэнгэр уул, нуруудаас эх авсан Амударья, Сырдарья, Или, Талас, Иртиш, Обь зэрэг гол мөрнүүд энэ бүс нутгийн экосистем, соёл иргэншлийг тэтгэн байдгаараа онцлогтой.



Зураг 1. Төв Азийн гол мөрний ай сав ба эдийн засгийн нөлөөлөл.

Мирзабаев А. 2012 он.

Төв Азийн усны нийт хэрэглээний 90 орчим хувь нь газар тариаланд зарцуулагддаг ба хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх нь ч бий. Тухайлбал, хөвөнгийн тариалангийн усалгааны систем нь Арал тэнгисийн эко системийн сүйрлийг дагуулсан байдаг. Кыргызстан болон Тажикстан улс нь уулын орны хувьд усны эх үүсвэрийг дийлэнхийг нийлүүлдэг ч усны хэрэглээ нь бусад улсуудыг бодвол харьцангуй бага байдаг.

Харин Узбекистан, Туркменистан, Казахстаны хувьд доод урсгалын бүсэд орших бөгөөд цаг уурын өөрчлөлт, мөсөн голын хайлалт болон усны эхийг эзэмшдэг улс орнуудын нөлөөлөл (жишээ нь: усан цахилгаан станц), улирлын хэлбэлзлээс хамааран усны хомсдолд орох эрсдэл өндөртэй гэж үздэг. Усны эх үүсвэр болон урсгал дайран өнгөрдөг улс орны хамаарлыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1. Төв Азийн улс орнууд ба Усны менежмент, геополитикийн нөлөөлөл

Гол мөрөн	Эх үүсвэрийн улс	Урсгал дайран өнгөрдөг улс	Гол хэрэглээ	Их гүрнүүдийн оролцоо
Амударья	Тажикстан, Афганистан	Узбекистан, Туркменистан	Хөдөө аж ахуй (хөвөнгийн талбай)	Хятад: “Бүс ба Зам” төсөл, усны дэд бүтэц; ОХУ: бүсийн аюулгүй байдал; АНУ, ДБ: санхүүжилт
Сырдарья	Кыргызстан	Узбекистан, Казахстан, Тажикистан	Хөдөө аж ахуй, эрчим хүч	Хятад: усан цахилгаан станцын хөрөнгө оруулалт; ОХУ: эрчим хүчний нөлөө; ЕХ: усны хамтын ажиллагааны төсөл
Или	Хятад (ШУӨЗО)	Казахстан	Ундны ус, хөдөө аж ахуй	Хятад: дотоодын ус таталт; Казахстан: нуурын түвшин хамгаалах; ОУБ (UNESCO): Байгаль орчны хамгаалалт
Талас	Кыргызстан	Казахстан	Хөдөө аж ахуй	Казахстан–Кыргызстаны хоёр талт гэрээ; ОУХБ-ийн зуучлал
Обь (Енисейтэй холбогддог систем)	ОХУ	Казахстан (усны нөлөөтэй бүс)	Ундны ус, эрчим хүч	ОХУ: бүсийн усны бодлого; Хятад: усны худалдаа, хамтын ажиллагаа

Төв Азийн улс орны усны менежмент, хуваарилалтын асуудалд Их гүрнүүдийн бодлогын нөлөөллийг авч үзвэл дараах мэт. Үүнд:

1. ОХУ-ын нөлөөлөл

ЗХУ-ын үед Төв Азийн бүс нутаг нь нэгдсэн, төвлөрсөн удирдлагатай усны менежментийн системтэй байв. Усны нөөцийн стратеги нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, ялангуяа хөвөнгийн тариалалт болон тариалангийн усалгааг дэмжих зорилготой байжээ¹. ЗХУ-ийн төлөвлөгөөт эдийн засгийн хүрээнд бүс нутгийн улс орнуудыг усны эх үүсвэр, хэрэглээний чиглэлээр тусгайлан ангилж, уулын бүс (Кыргызстан, Тажикистан)-ийг усны хадгалалт, эрчим хүчний үйлдвэрлэлийн бүс, доод урсгалын орнууд (Узбекстан, Казакстан, Кыргызстан)-ыг усалгааны хөдөө аж ахуйн бүс болгон зохион байгуулжээ². Энэ бодлогын хүрээнд томоохон гидротехникийн байгууламжууд (Токтогул далан, Нурек УЦС, Каракум сувгийн систем, Ферганы суваг г.м) баригдаж, бүс нутгийн гол мөрөн болох Амударья,

¹ Food and Agriculture Organization of the United Nations (FAO). (1992). Irrigation in the countries of the former Soviet Union in figures. FAO Water Reports 7. Retrieved from <https://www.fao.org/4/a0415e/A0415E08.htm>

² House of Commons Foreign Affairs Committee. (1999). Central Asia: Water resources and regional stability. House of Commons, United Kingdom. Retrieved from <https://publications.parliament.uk/pa/cm199899/cmselect/cm/aff/3>

Сырдарьягийн урсгалыг удирдах боломж бүрдүүлсэн³. Төвлөрсөн усны менежментийн энэхүү систем нь тухайн үед үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжсэн ч байгаль орчинд сөрөг үр дагавар дагуулсан. Тухайлбал: Хөвөнгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр усны менежмент явуулсан нь Арал тэнгисийн түвшин буурч, экосистемийн сүйрэлд хүргэсэн нь энэ бодлогын хамгийн том алдаа байсан⁴. Үүнээс гадна ЗХУ-ын усны салбар нь институциональ бүтэц, судалгаа, инженерийн сургуулийг хөгжүүлснээр мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж, олон улсын түвшний гидротехникийн туршлага хуримтлуулсан нь өнөөг хүртэл бүс нутгийн усны удирдлагын суурь хэвээр байна⁵. Гэвч эдгээр бүтэц нь ЗХУ задран унаж харьяанд нь орж асан улс орнууд тусгаар тогтносон улс болсны дараа улс хоорондын маргаан, хамаарал бий болгох нөхцөлийн үндэс болжээ⁶.

Орчин үед ОХУ нь Төв Азийн улс орнуудыг геополитикийн хүрээлэлдээ хадгалж, усны асуудлаар дамжуулан стратегийн байр сууриа тогтвортой хадгалах зорилт тавьж байна. Сүүлийн жилүүдэд ОХУ усны салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор хэд хэдэн бүс нутгийн санаачилга хэрэгжүүлж байна. Тухайлбал: Евроазийн эдийн засгийн холбоо болон Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ын хүрээнд усны нөөцийн хамтын ажиллагааны менежмент, усан цахилгаан станцын төсөл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох гэсэн сэдвийн хүрээнд хамтарсан судалгаа гүйцэтгэхийг дэмжиж байна⁷. Мөн ОХУ нь усны нөөцийн “зөөлөн хүч”-ээ ашиглан эрчим хүчний бодлого, дэд бүтцийн хөрөнгө оруулалтаар дамжуулан Төв Азийн таван улсад нөлөөлж буй. Тухайлбал: Сибирийн усны илүүдэл нөөцийг Төв Азид чиглүүлэх тухай санаачилга олон удаа дэвшүүлэгдэж байсан ч энэ нь чухамдаа ОХУ-ын зүгээс бүс нутгийн усны хомсдолыг ашиглан стратегийн оролцоогоо нэмэгдүүлэх бодлогын нэг илэрхийлэл юм⁸.

2. БНХАУ-ын нөлөөлөл

Шинжаан нь Или болон Иртыш мөрний эх дээр оршдог бөгөөд эдгээр голууд нь Казахстан болон бусад Төв Азийн улсын усны геополитикийн чухал хэсэгт тооцогдоно. БНХАУ нь Шинжаан дахь хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, үйлдвэржилт, төслүүд олширсоноор ус таталтын хэмжээ өссөн нь доод урсгал дахь улс орнуудын, тухайлбал Казахстаны хувьд усны хангамжид шууд аюул учруулж байна⁹. Жишээлбэл: Иртыш-Карамай-Үрэмч (635 дугаар төсөл) сувгийн

³ Wegerich, K., & Kazbekov, J. (2011). Revisiting water management in Central Asia: The legacy of the Soviet water system. In K. Wegerich & J. Kazbekov (Eds.), *The Water-Energy Nexus in Central Asia* (pp. 85–100)

⁴ Istituto Affari Internazionali (IAI). (2025). *Troubled water resources in Central Asia: The need for better management*.

⁵ Sehring, J. (2013). *Socio-technical aspects of water resources management in Central Asia*.

⁶ European Union–Central Asia Water Research Program. (2024). *Strategic water resources in Central Asia: In search of a new international legal order*

⁷ Vinokurov, E., Libman, A., & Pereboyev, V. (2020). Eurasian economic integration: Water-energy nexus in Central Asia. *Water Resources Management*, 34(9), 2815–2830

⁸ Molodikova, I., & Kuznetsov, A. (2021). Russia's geopolitical interests in Central Asia: Water resources and soft power. *Journal of Eurasian Studies*, 12(3), 245–258.

⁹ Eurasianet. (n.d.). *Xinjiang's growing thirst for water is raising fears of a major catastrophe in Kazakhstan*.

систем нь усны урсгалыг БНХАУ-ын зах зээл рүү чиглүүлэн татсанаар Казахстан дахь голчлон хөдөө аж ахуй, ундны болон аж үйлдвэрийн хэрэглээнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл байдал бий болжээ¹⁰.

Шинжаан дахь хүн амын өсөлт, “Барууны хөгжлийн бодлого” (Go to West policy) болон газрын тосны олборлолт зэрэг хүчин зүйлүүд усны хэрэглээг эрс нэмэгдүүлж байна. Нийтдээ Хятадын усны хэрэглээ нэмэгдэх тусам доод урсгалд орших улсуудын усны хүртээмж буурах чиг хандлагатай байна¹¹. Өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг даган усны урсац багасах тусам Казахстан дахь Балхаш нуур болон Или голын эргэн тойрон дахь экосистемд аюулын нөхцөл үүсэж байна. Жишээлбэл: экосистемийн алдагдал, элс шуурга болон усны хомсдолын улмаас Балхаш нуурт Арал тэнгис орчмын нэгэн адил нөхцөл байдал үүсэж болзошгүйг экологичид анхааруулж байна¹².

Шинжаанд хэрэгжүүлж буй усны төслүүд нь Тарим, Или, Иртыш зэрэг олон улсын ай сав газарт хамаарагдах гол мөрний урсцыг зохицуулах бодлого нь Амударья, Сырдарья голуудын урсац, тэдгээрийн хамааралтай бүс нутгийн усны аюулгүй байдалд урт хугацааны эрсдэл дагуулж байна¹³.

Мөн “Бүс ба зам” санаачилгын хүрээнд Шинжааны эдийн засгийн хөгжил түргэссэнээр бүс нутгийн усны эргэлт нэмэгдэж, Ойрхи Дорнод, Төв Азийн усны нөөцийн стратегийн ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна¹⁴.

Казахстан болон БНХАУ 2001 онд усны чиглэлээр хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, усны менежмент, мэдээлэл солилцох, хоёр улсын мэргэжлийн харилцааг хөгжүүлэхэд анхаарч байсан ч одоог хүртэл дорвитой үр дүнд хүрээгүй байна¹⁵. 2025 оны байдлаар усны аюулгүй байдлыг хангахын тулд БНХАУ-ын болон Төв Азийн улс орнуудын хооронд усны менежмент болон технологийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх, илүү бодитой үр дүнтэй хамтын ажиллагааг өрнүүлэх шаардлага улам бүр тулгарч байна¹⁶.

3. АНУ-ын нөлөөлөл

АНУ-ын усны геополитик Төв Азид нь уламжлалт хандлага (аюулгүй байдал, тогтвортой хөгжил) ба шинэ чиг хандлага “ус бодлого бол гадаад харилцааны бодлогын хэрэгсэл” гэсэн ойлголтыг хослуулан хэрэгжүүлж байна. АНУ голчлон техникийн тусламж, институцийн чадавхыг хөгжүүлэх, бүс нутгийн олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх (C5+1) замаар усыг “зөөлөн хүч” хэлбэрээр ашигладаг бол урсгалын доод биед орших улсуудын хувьд усыг үндэсний аюулгүй

¹⁰ Wikipedia. (2025). Irtysh–Karamay–Ürümqi Canal (Project 635)

¹¹ Jamestown Foundation. (n.d.). China's development plans in Xinjiang threaten Kazakhstan's water security.

¹² Eurasianet. (n.d.). Xinjiang's growing thirst for water is raising fears of a major catastrophe in Kazakhstan

¹³ Liu, J., Yang, H., Gosling, S. N., Kumm, M., Flörke, M., Pfister, S., ... & Oki, T. (2020). Water scarcity assessments in the past, present, and future. *Earth's Future*, 8(6)

¹⁴ Xie, P. (2021). China's Belt and Road Initiative and transboundary water governance in Central Asia. *Water International*, 46(4), 450–465

¹⁵ Eurasianet. (n.d.). Xinjiang's growing thirst for water is raising fears of a major catastrophe in Kazakhstan

¹⁶ Atlantic Council. (2025). Central Asia needs regional and international cooperation to bolster water security

байдлын хүрээнд авч үзэх бодлогыг хэрэгжүүлж байна¹⁷.

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID) нь Сырдарья, Амударья мөрний сав газарт “Regional Water and Vulnerable Environment” (WAVE) хөтөлбөрийг 2020-2025 онд хэрэгжүүлж байна. Энэхүү \$24-24.5 саяын төсвөөр хэрэгжиж буй хөтөлбөр нь янз бүрийн усны түвшинд усны нөөцийн удирдлагыг сайжруулах, салбар хоорондын уялдааг нэмэгдүүлэх, тогтвортой менежментийн чадварыг бэхжүүлэх зорилготой¹⁸. 2023 онд тус хөтөлбөрөөс суралцагчид усны менежментийн арга туршлага, загварчлал боловсруулах, залуу судлаачдыг бэлтгэх зэрэг үйл ажиллагаа явуулжээ.

USAID-ийн судлаачид, усны мэргэжилтнүүд засгийн газрын төлөөллүүдийг хамарсан аялал зохион байгуулсан. Тэнд Сырдарьягийн эхнээс нь Арал тэнгис хүртэл усны янз бүрийн түвшинд судалгаа хийж, дэд бүтэц, ус хэмжих болон зохион байгуулалтын туршилтыг судалжээ¹⁹.

Арал тэнгисийн гамшгийг судлан болзошгүй усны зөрчилдөөнийг сааруулахад тусламж үзүүлж, 2002 онд USAID-ийн санхүүжилттэй “River Forest System” (RFS) боловсруулж, ус хаана, ямар хэмжээтэй унах зэргийг тооцоолж, усны менежментийг сайжруулахад хувь нэмэр оруулсан²⁰.

2015 оноос эхлэн АНУ болон “5 стан” буюу C5+1 хэлэлцүүлэг зохион байгуулж байна. Энэхүү хэлэлцүүлгийн хүрээнд “Smart Waters” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлснээр усны менежментийн мэргэжилтэнүүдийг бэлтгэж, усны салбарт бодлогын шийдлүүдийг хамтарч боловсруулахаар зорьж байна²¹. АНУ-ын “Global Water Strategy 2022-2027” нь Төв Азийн улс орнуудад усны нөөцийн тэгш хуваарилалт, тогтвортой хэрэглээг дэмжихэд чиглэсэн бөгөөд USAID-ээр дамжуулан 1 тэрбум гаруй ам.доллар хөрөнгө оруулж байна гэж зарим судалгаанд дурдагдсан нь АНУ-ын геополитикт усны стратегийн чухал байр суурийг илтгэж байгаа юм. Энэ стратеги нь уур амьсгалын өөрчлөлт, ус-энерги-хүнс гэсэн эргэх холбоо зэргийг харгалзан үздэг тул илүү өргөн хүрээтэй геополитик бодлого гэж үздэг.

АНУ-ын оролцоо нь ОХУ, БНХАУ-ын бүс нутгийн суурь нөлөөнд тэнцвэр бий болгох зорилготой. Усны төсөл, усны институтийн бэхжилт нь геополитикийн шугаман цэг болж, АНУ-ын тусламжийг хүлээн авсан улс орнууд урт хугацааны харилцаа бий болох нь ойлгомжтой байна.

4. ЕХ-ны нөлөөлөл

Европын Холбоо нь 2019 онд баталсан шинэ Төв Азийн стратеги (EU Strategy on Central Asia 2019)-ийн хүрээнд “Ус ба энерги” бүс нутгийн хамтын ажиллагааны тэргүүлэх салбаруудын нэгээр тодруулсан бөгөөд усны асуудлыг цаг уур, экологийн

¹⁷ U.S. Global Water Strategy. (2022). U.S. Global Water Strategy 2022–2027. U.S. Government

¹⁸ USAID. (2020, September 30). New USAID Program to Strengthen Transboundary Water Cooperation in Central Asia

¹⁹ USAID. (2020, September 30). New USAID Program to Strengthen Transboundary Water Cooperation in Central Asia

²⁰ https://www.wired.com/2002/09/thirst/?utm_source=chatgpt.com

²¹ The White House. (2023, September 21). C5+1 leaders' joint statement.

сорилтой уялдуулан авч үздэг²². 2021-2027 он хүртэлх “Regional Multiannual Indicate Programme” хүрээнд ЕХ-ний улс орон бүрийн усны реформ, дэд бүтэц, сав газрын түвшний хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн²³. ЕХ-оос Төв Азид хандуулсан төсөл хөтөлбөрүүдийн зарим нэгээс цухас танилцуулбал:

- WECOOP (Water & Environment and Climate Change Cooperation)-ийг ЕХ нь 2009 онд байгуулаад 2019 онд дахин шинэчилсэн. Энэхүү платформ нь Төв Азийн орны ус, экологийн менежмент, хуулийн зохицуулалтад ЕХ-ний стандартыг нэвтрүүлэхэд чиглэгдэж байна²⁴.
- CAWER (Central Asia Water & Energy Program)-ийг ЕХ, Дэлхийн банк, Швейцар, Их Британи зэрэг байгууллага, улс орнууд хамтран хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь Төв Азид ус ба эрчим хүчний аюулгүй байдлыг сайжруулах зорилготой олон талт үйл ажиллагаа эрхэлдэг сан юм²⁵.
- Team Europe Initiative on Water, Energy and Climate Change нь ЕХ-оос нийлүүлэлтээр 700 сая евро, үүнээс 200 сая евро нь шууд ЕХ-оос хуваарилагдсан бөгөөд хөтөлбөр нь ус, энерги, уур амьсгалын чиглэлд бүс нутгийн нэгдсэн, хариуцлагатай шийдэл бий болгох зорилготой²⁶.

Мөн ЕХ нь IFAS (International Fund for Saving the Aral Sea)-тай хамтран Арал тэнгист усны экосистемийг нөхөн сэргээх, усны менежментийг дэмжихэд чухал оролцоо үзүүлдэг. 2022 онд Казакстанд болсон ECOJER “Green Life Better” бага хурлын үеэр ЕХ-ний судлаачдын илтгэлд уур амьсгалын өөрчлөлт, мөсөн голын хайлалтын улмаас үүсэж буй усны хомсдол, усны өрсөлдөөн зэрэг геополитикийн аюул заналын талаар анхаарал татсан зүйл ажиглагдсан байдаг.

Тажикстан улсад Дэлхийн банктай хамтран ЕХ нь усан цахилгаан станц барих, засварлах 3 мега төсөлд хөрөнгө оруулалт хийснийг Дэлхийн банкны веб сайтаас харж болох юм.

2025 онд Самарканд хотноо болсон ЕХ-Төв Азийн улс орнуудын анхны дээд хэмжээний уулзалт нь ус, эрчим хүч, тээвэр, дижитал холболт зэрэг салбарт 12 тэрбум еврогийн хөрөнгө оруулалт бүхий “Gateway Investment Package”-ийг танилцуулснаар стратегийн түншлэл бэхэжсэн юм²⁷.

5. Төв Азийн улс орнуудын усны геополитик ба сорил

ЗХУ задарсны дараа Төв Азийн усны менежмент нь бусад улсын төр, эдийн

²² European External Action Service (EEAS). (2019). 2019 EU Strategy on Central Asia: Water and energy cooperation

²³ European External Action Service (EEAS). (2022, June 2). EUSR remarks on sustainable development of water resources in Central Asia

²⁴ EU-Central Asia Platform on Environment and Water Cooperation (WECOOP). (2019, October). The EU's WECOOP project to continue support for sustainable development and circular economy in Central Asia

²⁵ CAWater-Info Yearbook. (2023). Activities of international partners in Central Asia – EU.

²⁶ European External Action Service (EEAS). (2022, June 2). EUSR remarks on sustainable development of water resources in Central Asia.

²⁷ AP News. (2025, April 4). EU leaders hold their first summit with Central Asian states

засгийн системтэй уялдаж зохицуулагдах болсон. Upstream буюу уулсын орнууд болох Тажикстан, Киргизстан нь усны нөөц хадгалах, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд анхаарч байсан бол Downstream буюу доод урсгалын улс орнууд болох Казакстан, Узбекистан, Туркменистан нь голчлон газар тариалангийн буюу усалгааны системд анхаарал хандуулж байна. Энэ нь газар тариалан болон эрчим хүчний эрэлтэд тулгуурлагдсан шугаман бус хуваарилалт болон сөргөлдөөн үүсэх нөхцөл болж байна²⁸.

1992 онд Төв Азийн таван улс “Алматы гэрээ” нэрээр мэдэгдсэн усны менежментийн хэлэлцээрт гарын үсэг зурж, International Commission for Water Co-ordination (ICWC) байгуулсан. Гэвч энэ институт нь тодорхой үр дүнгүй хэвээр үлдсэн бөгөөд доод урсгалын улс орнууд дээд урсгалын улс орнуудын эрчим хүчний зорилт, усны нэмэгдэл хэрэгцээтэй уялдан найрсаг хуваарилалтыг хангаж чадаагүй²⁹.

Ферганы хөндийн ай сав, Исифа, Кожобакирган болон Козу ба Баглан голууд нь Кыргызстан ба Тажикистаны хооронд усны сөргөлдөөн үргэлжлэх шалтгаан болж байна. Энэхүү гол дээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, ус таталт нь шууд хоёр улсын хооронд талцалд хүргэж, өнөөг хүртэл асуудал дагуулсан хэвээр байна. 1962 оны гэрээгээр 79%-ийг Тажикстан, 21%-ийг Кыргызстан эзэмшдэг.

Цаг агаарын өөрчлөлт, мөсний хайлалт зэргээс үүдэн усны гачаал нэмэгдэж, эмзэг хүрээнд усны зөрчил хурцдаж байна. Тажикстан болон Кыргызстан “upstream” улсууд усны нөөцтэй ч “downstream” улс орнуудыг хангах талаар давамгайлал үзүүлэхэд илүү төвлөрсөн стратеги баримталж байна. Энэ байдал нь бүс нутгийн улс төрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг болохыг олон судалгааны баримтаар нотлогддог³⁰.

Орон нутгийн болон олон улсын усны асуудлыг шийдвэрлэх хуулийн орчин сул хэвээр байгаа нь сөргөлдөөн даамжрахад гол нөлөө үзүүлдэг болов уу. Барууны буюу Европын улсуудаас хэрэгжүүлж буй санхүүжилт, төсөл хөтөлбөр, шийдлүүд нь оновчтой хамтын ажиллагаа руу чиглэх ёстойг дэлхийн олон орны судлаачид онцолдог³¹ байна.

ДҮГНЭЛТ

ЗХУ задран унасны дараа Төв Азид “С5 буюу 5 стан” буюу Кыргызстан, Тажикстан, Узбекистан, Туркменистан, Казахстан гэсэн улсууд тусгаар тогтносон байдаг. ЗХУ-ын үед усны нэгдсэн удирдлагатай, мэргэжилтэн болон боловсон хүчнийг социалист чиг баримжаатайгаар бэлтгэдэг байжээ. Энэ үед улс орнуудын усны асуудлыг Холбооны улсын дотоод гэрээгээр зохицуулдаг байсан бөгөөд ЗХУ задран унаснаар тусгаар тогтносон улс орнууд 1992 онд “Алматы гэрээ”-ээр

²⁸ European Parliamentary Research Service (EPRS). (2015, October 28). *Water disputes in Central Asia: Rising tension threatens regional stability*

²⁹ Climate-Diplomacy. (2024, June 21). *The future of water in Central Asia*.

³⁰ International Affairs Institute (IAI). (2025, May 30). *The troubled water resources of Central Asia need better management*

³¹ Atlantic Council. (2024, November 27). *The West's role in solving Central Asia's water crisis*

зохицуулахыг оролдож байгаа ч үр дүн муутай байна.

Дээд урсгалын улс орнуудын нэг гол төлөөлөл болох БНХАУ-ын зүгээс өөрийн өсөн нэмэгдэж хүн ам, ШУӨЗО-ны эдийн засгийн өсөлтийг хангахын тулд усны хэрэгцээгээ нэмэгдүүлж байгаа бол Тажикстан болон Кыргызстаны хувьд эрчим хүчний ЦС барих асуудал нь газар тариалангийн орон болох Узбекистан, Туркменистан, Казакстаны эдийн засаг болон хүн амын ундны усны хомсдолд орох эрсдэл нүүрлэж байна. Үүнд мөн цаг агаарын дулаарал, мөсөн голуудын хайлалт, улирлын хэлбэлзэл хүчтэй нөлөө үзүүлж байгааг дурдах нь зүйтэй.

ОХУ-ын зүгээс Төв Азийн бүс нутагт өөрийн нөлөөллийг хадгалах, бэхжүүлэх стратеги боловсруулан зарим нэг шийдлийг санал болгож байна. Жишээ нь, Сибирийн илүүдэл усны нөөцийг санал болгож байна. Ингэснээрээ дээд урсгалын орны давуу байр суурийг бий болгох боломжтой юм. Харин БНХАУ-ын зүгээс Төв Азийн улс орнуудад усны менежментийн талаар хамтран ажиллах санал тавьж байгаа ч нөгөө талаас өөрийн давуу байр суурийг хадгалсан хэвээр байна.

Харин АНУ-ын баримталж буй бодлого нь ОХУ, БНХАУ-ын геополитикийн хүчийг тэнцвэржүүлэхэд анхаарч байгаа ч одоогоор бага нөлөөтэй ч энэ бүс нутагт ОХУ, БНХАУ-ын өрсөлдөгч болон гарч ирж байна. Европын холбооны зүгээс АНУ-ын стратегитай уялдуулсан бодлого буюу дэмжих байдлаар нөлөөлж байгаа ч нөгөө талаараа дээд урсгалын улс орнуудад ЦС-ын хөрөнгө оруулалтыг ихээр хийж байгаа нь доод урсгалын улс орнуудын нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Цаашид Төв Азийн улс орнуудын усны асуудал нь бүс нутгийн аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдалд чухал нөлөөтэй бөгөөд Их гүрнүүдийн дэлхийн бүс нутгуудад нөлөөгөө тогтоох өрсөлдөөний нэгэн талбар болоод байна. Цаашид энэ бүс нутагт тогтвортой байдлыг хангахын тулд усны менежмент, олон улсын хууль эрхзүйн тогтолцоог шинэчлэх, хил дамнасан усны нөөцийн ашиглалтыг зохицуулах олон улсын эрхзүйн гэрээ чухал ач холбогдолтой байна.

Манай улсын хувьд дээд урсгалын буюу стратегийн давуу байрлалтай бол ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын хувьд доод урсгалын улс болох нь харагдаж байна. Мөн дэлхийн цэвэр усны 20 хувийг эзэлдэг Дэлхийн өв буюу Дэлхийн цэвэр усны хамгийн том нөөц болох Байгаль нуурын нөөцөд нөлөөлөх эсэхийг шинжлэх ухааны үндэслэлтэй нарийн тооцоо хийж, ОХУ-тай олон талт хамтын ажиллагаагаа олон улсын эрхзүйн зохицуулалттай нийцүүлэн гэрээ хэлцэл хийх нь стратегийн хамгийн боломжит зөв хувилбар байх болов уу.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Allan (2001) “hydro-politics” концепцийг ашиглан усны маргаан бүхий бүс нутгийг судалсан.
2. Gleick (2014) усны хомсдол нь улс төр, нийгмийн тогтвортой байдалд нөлөөлөх эрсдэлтэйг тэмдэглэжээ.
3. Weinthal (2002) СЭХ-ийн ус-эрчим хүчний солилцооны уламжлал бүс нутгийн харилцаанд хэрхэн нөлөөлж буйг судалсан.
4. Snetkov & Watanabe (2015) Оросын нөлөөллийг дэд бүтэц, эрчим хүчний холбоосоор

тайлбарласан.

5. Jalilov et al. (2016), Pak (2021) Хятад, Орос, АНУ-ын усны менежментийн стратегийг харьцуулсан судалгаа.

Эдгээр судалгаанууд нь Төв Азийн усны геополитикийн харилцаанд их гүрнүүдийн оролцооны чухлыг онцолж байна.

Судалгааны арга:

- Баримт бичиг, судалгаа (БНХАУ, ОХУ, АНУ, ЕХ)
- Олон улсын байгууллагын тайлан (World bank, UNECE, CAREC)
- Peer-reviewed өгүүллүүд
- Кейс судалгаа (Амударья, Сырдарья, Арал тэнгис)